



ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.11.01 № 01/2337

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240102522/02/01 дугаартай “Хяналтын камер” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт ... хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124051247

Тодруулгын хариу

Тендерийн нэр	Хяналтын камер нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер
Тендерийн дугаар	ЭТТХК/20240102522/02/01
Тендер зарласан огноо	2024 оны 10 дугаар сарын 02
Тендер нээх огноо	2024 оны 11 дүгээр сарын 05
Тодруулга	
Тодруулга	Хариу
<p>Үйлдвэрлэгч, дистрибьютер, албан ёсны гэрээт борлуулагчийн аль нэгээр ажилладгийг нотлох баримт бичиг ирүүлнэ (Гадаад хэл дээрх гэрээний хуулбар, гэрчилгээний хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ) гэсэн заалтыг техникийн тодорхойлолт хэсгийн нэмэлт шаардлага дээр “хяналтын камерын” гэж барааг заасан байна. Харин ӨХ-ийн ТШЗ 18.2 дээр ямар бараа гэдгийг заагаагүй байгаа тул зөвхөн хяналтын камер дээр гэрээний хуулбар болон гэрчилгээний хуулбарыг ирүүлж болох уу?</p>	<p>Зөвхөн хяналтын камер дээр үйлдвэрлэгч, дистрибьютер, албан ёсны гэрээт борлуулагчийн аль нэгээр ажилладагийг нотлох баримт бичиг ирүүлж болно. (Гадаад хэл дээрхи гэрээний хуулбар, гэрчилгээний хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ)</p>
<p>Мөн хяналтын камераас бусад бараан дээр гэрээт борлуулагчийн итгэмжлэл авч байгаа тохиолдолд итгэмжлэл олгож байгаа байгууллагын партнер эсвэл дистрибьютерын гэрчилгээний хуулбар нь гадаад хэл дээрх гэрээний хуулбарын хамт байх хэрэгтэй юу?</p>	<p>Шаардлагагүй.</p>
<p>Техникийн тодорхойлолт хэсгийн нэмэлт шаардлага №9. Бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, бүрэн бүтэн байх бөгөөд бүх бараа,</p>	<p>Тендерийн баримт бичгийн Техникийн тодорхойлолтын 4.4 “Нийт камер, тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, тоо ширхэг, тоног төхөөрөмжийн жагсаалт” гэсэн хүснэгтийн</p>

материалын модель, дэлгэрэнгүй тодорхойлолтыг зураг, каталогийн хамт ирүүлсэн байх гэж заасан байна. Харин техникийн тодорхойлолт хэсгийн 4.4 Тоног төхөөрөмжийн жагсаалт хүснэгтийн бүтээгдэхүүний загвар танилцуулга ирүүлэх гэсэн баганад 15 бараан дээр “Тийм” буюу загвар танилцуулга ирүүлэх гэж тэмдэглэсэн байна. Тиймээс 4.4 Тоног төхөөрөмжийн жагсаалт хүснэгтийн бүтээгдэхүүний загвар танилцуулга ирүүлэх гэсэн баганад зааснаар зөвхөн 15 барааны танилцуулга ирүүлж болох уу?

“Бүтээгдэхүүний загвар, танилцуулга ирүүлэх” гэсэн баганад “Тийм” гэж заасан 15 нэр төрлийн бараан дээр барааны танилцуулга буюу бараа, материалын модель, дэлгэрэнгүй техникийн тодорхойлолтыг фото зураг, каталогийн хамт ирүүлнэ.